

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан Бодох Бүртгэл
ТХН	Төсөл Хэрэгжүүлэгч Нэгж
МСҮТ	Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ 3243-MON
ТӨСӨЛ”-ИЙН ЗАХИРАЛ А.ХАЛИУНАА
ТАНАА

2020.04.30 № 06/1444
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх 3243-MON төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг сайжруулах төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх 3243-MON төсөл”-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх 3243-MON төсөл”-ийн аудитаар илэрсэн 15,995,978.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их байгаа нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, тохиолдсон байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх 3243-MON төсөл” нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн захирал А.Халиун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн худалдан авалтуудыг НӨАТ-ын нэгдсэн хэрэглэгчийн системд бүртгүүлэх, төлбөрийн баримт /э-баримт/-ыг анхан шатны баримтад бүрэн хавсаргах, түрээслэх байр талбайн хэмжээг тогтоосон дээд хязгаараас хэтрүүлэхгүй байх, шилэн дансны мэдээллийг цаг тухайд тайлагнах талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 02-ноос 2020 оны 4 дүгээр сарын 15–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Грант Торнтон аудит” ХХК-ийн аудитын менежер Б.Дэлгэрмаа, туслах аудитор Б.Эрдэнэбат, туслах аудитор Б.Тэнгис нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 52/43 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төслийн зорилгыг “Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх гурван салбар болох хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн сайжруулах, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ.” гэж тодорхойлжээ.

Тайлант онд “Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв”-ийн байрны засварын ажлыг гүйцэтгэж, Дорнод, Говь-Алтай аймгуудын МСҮТ-ийн засвар 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Ерөнхий боловсролын сургуулиудад хүлээлгэн өгөх лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах ажил 80-90 хувьтай хийгдсэн. Үндэсний сургалтыг 2019 оны 8 дугаар сард зохион байгуулж, нийт 82 сургагч багш ажиллаж, 4 мэргэжлийн 5,438 багшийг сургалтад хамруулсан байна.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл” нь НББ-ийн бодлогогүй боловч нягтлан бодох бүртгэлээ хөтлөхдөө Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан “Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй зээлийн болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн газрын тусгай сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар”, санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэх үлгэрчилсэн загвар”-ыг дагаж мөрдөж байгаа нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл” нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Эмералд програм хангамж ашигладаг байна.

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 17,448,915.1 мянган төгрөгөөс тооцон 174,489.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,743,370.5 мянган төгрөгөөр буюу 20.3 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	728,172.5	3,740,297.1	3,012,124.6
Урьдчилгаа	-	14,751,504.1	14,751,504.1
Үндсэн хөрөнгө	146,628.1	126,369.9	(20,258.2)
Нийт хөрөнгө	874,800.6	18,618,171.1	17,743,370.5
Өр төлбөр	8,043,998.4	2,715.0	(8,041,283.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	(7,169,197.8)	18,615,456.1	25,784,653.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	874,800.6	18,618,171.1	17,743,370.5

Мөнгөн хөрөнгө 2019 онд олгосон санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалан өссөн байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл өссөн нь төслийн зориулалтаар худалдан авахаар төлсөн тоног төхөөрөмж, их засварын ажлын урьдчилгаа төлбөртэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны аудитын тайланд дараагийн аудитаар авч үзэх чухал асуудлаар дурдсан АХБ-ны зээлийн үлдэгдэл 8,043,998.4 мянган төгрөгийг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснийг залруулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 18,615,456.1 мянган төгрөг болж 25,784,653.9 мянган төгрөгөөр өссөн нь зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр өмнө жилүүдээс өндөр батлагдсанаас шалтгаалжээ. Энэ нь “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 8,043,998.5 мянган төгрөгийн бичилт нь олон улсын санхүүгийн байгууллагаас авсан өмнөх онуудын зээлийн хуримтлагдсан үлдэгдлийг тайлант оны орлогоор бүртгэснийг аккруэл суурийн дагуу өмнөх үр дүнг нэмэгдүүлсэн.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийг хэрэгжүүлэхэд зориулан 18,812,612.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,539,612.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 15,273,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Азийн хөгжлийн банкнаас 20,335,365.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон, харилцах дансны хүүгийн орлого 44,048.4 мянга, бусад орлого 9,627.6 мянга, нийт 20,389,041.6 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 17,428,273.0 мянган төгрөг буюу 92.6 хувьтай байна. Улсын төсөвт 44,048.4 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 38,791,751.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 22,795,773.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 31,179.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 15,964,798.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

1. Тайлант хугацаанд Хувь хүнтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу төлсөн нийт 130,435.6 мянган төгрөгийн төлбөрт ногдуулах 19,861.6 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл, 11,317.5 мянган төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг тус тус суутгаагүй, харьяа татвар болон нийгмийн даатгалын албад тайлагнаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.2 "Албан татвар төлөгч энэ хуулийн 11.1.6, 12 дугаар зүйл, 13.1.1, 14.1.2, 14.1.3-т заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.1-д заасан хувиар, 8.1.6-д заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.2.2-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулан төлж, албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэн харьяа татварын албаар баталгаажуулах бөгөөд татварын жилийн эцэст уг албатай татварын тооцоо хийнэ.", Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.2 "Нийгмийн даатгалд өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Биет бус хөрөнгө, биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдуулга дансны эхний үлдэгдэл нь өмнө оны аудитлагдсан үлдэгдлээс 271.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.2 "тасралтгүй байх" заалттай нийцэхгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

3. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлсөн 14,751,504.1 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3.2 "Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын дансуудад хуримтлуулан бүртгэнэ" заалттай тус тус нийцэхгүй, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

4. Өмнөх оны аудитын тайланд дараагийн аудитаар авч үзэх чухал асуудлаар дурдсан АХБ-ны зээлийн үлдэгдэл 8,043,998.4 мянган төгрөгийг тайлант оны орлогоор хүлээн

зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 2.2 "Ажил үйлчилгээ (нийлүүлсэн бүтээгдэхүүн)-ний орлогыг аккруэл суурьт үндэслэн тайлант хугацааны туршид хуримтлуулан бүртгэнэ." заалттай тус тус нийцэхгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл” Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 10 мэдээллийг хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 15,995,978.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 174,489.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

“Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх MON-3243 төсөл”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1.Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1.Илрүүлэлт:

Тайлант хугацааны 16,569,387.1 мянган төгрөгийн худалдан авалтыг НӨАТ-ын хэрэглэгчийн системтэй тулган шалгахад 616,517.5 мянган төгрөгийн НӨАТ-с чөлөөлөгдсөн худалдан авалт, 2,886.4 мянган төгрөгийн НӨАТ-с чөлөөлөгдөөгүй худалдан авалт бүртгэгдсэн боловч 15,952,869.6 мянган төгрөгийн худалдан авалт бүртгэгдээгүй, төлбөрийн баримт /э-баримт/-ыг анхан шатны баримтад бүрэн хавсаргаагүй нь харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд НӨАТ-ыг санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлсэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтыг ТХН хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нь борлуулалтын орлогоо санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй." заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Гэрээтэй байгууллагуудын төлбөр нь бүрэн төлөгдөж дуусаагүй байна. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажилтан цаг тухай бүрд нь хуулийн дагуу гэрээт байгууллагуудаас шаардаж байсан боловч байгууллагууд ихэвчлэн гэрээний эцсийн төлбөр төлөгдөхөд борлуулалтаа системд бүртгэнэ гэсэн тайлбар өгдөг.

3.2.1 Илрүүлэлт:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр “Натур тур” ХХК-тай 140 м.кв талбайг 40.0 мянган төгрөгөөр түрээслэхээр №2018/09 тоот гэрээ байгуулж тайлант онд нийт 41,330.2 мянган төгрөг төлсөн байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018 оны №01 дугаартай хуралдааны тэмдэглэлд заасан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн дээд хязгаар 30.0 мянган төгрөгөөс ихгүй байх” заалтыг зөрчиж, нэг хүнд 8 м.кв байх нормыг хэтрүүлж, нийт 60 м.кв илүү түрээслэн тайлант оны түрээсийн зардалд 11,930.2 мянган төгрөг илүү зарцуулсан байна.

3.2.2 Эрсдэл:

Төслийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Түрээслэх байр талбайн дээд хязгаар 30.0 мянган төгрөгөөс ихгүй байх, 1 хүнд ноогдох талбайн хэмжээг мөрдөх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2019 онд “Натур тур” ХХК-д түрээсийн төлбөрт нийт 41,330.2 мянган төгрөг төлсөн бөгөөд энэ нь 1 м.кв талбайг 24.6 мянган төгрөгөөр түрээсэлсэн тооцоо гарч байна.

3.3 Шилэн данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар бүлэг 6 дугаар зүйлд заасан 10 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан байна.

3.3.2 Эрсдэл:

Төсвийн ил тод байдал хангагдахгүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар бүлэг 6 дугаар зүйл "Шилэн дансны мэдээлэл"-ийг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу

Шилэн дансны бүх мэдээллийг төслийн туслах ажилтан, худалдан авалтын туслах ажилтнууд цаг тухай бүрд хөтөлдөг. Сангийн яаманд төлбөрийн хүсэлт илгээхэд шилэн дансны мэдээлэл шаарддаг тул заавал хөтөлдөг. Хугацаа хоцорсон гэдэг нь жилийн батлагдсан төсвийг 12 дугаар сард Сангийн яамнаас дахин хуваарилалт хийж, зассантай холбоотой.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	728,172,519.73	18,491,801,196.02
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	728,172,519.73	3,740,297,117.09
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,237,267.53	-
31110	Төгрөг	1,237,267.53	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	726,935,252.20	3,740,297,117.09
31210	Төгрөг	246,708,310.15	262,109,466.54
31211	Төрийн сангийн харилцах	246,708,310.15	262,109,466.54
31220	Гадаад валют	480,226,942.05	3,478,187,650.55
31223	Арилжааны банк дахь харилцах	480,226,942.05	3,478,187,650.55
34	УРЬДЧИЛГАА	-	14,751,504,078.93
34710	Урьдчилгаа тооцоо	-	14,751,504,078.93
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	14,751,504,078.93
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	146,628,055.14	126,369,858.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	146,628,055.14	126,369,858.24
39200	Биет хөрөнгө	140,146,860.26	120,156,879.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	134,878,868.19	134,878,868.19
39204	Хуримтлагдсан элэгдэл	(37,782,336.24)	(51,262,837.44)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	40,175,080.71	40,175,080.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,644,703.00)	(21,214,015.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,425,082.00	29,425,082.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,905,131.40)	(11,845,297.65)
39300	Биет бус хөрөнгө	6,481,194.88	6,212,978.28
39301	Програм хангамж	7,013,219.04	7,013,219.04
39302	Хуримтлагдсан элэгдэл	(532,024.16)	(800,240.76)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	874,800,574.87	18,618,171,054.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,043,998,412.49	2,715,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,715,000.00
4136	Бусад өглөг	-	2,715,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,715,000.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,043,998,412.49	-
42200	Урт хугацаат зээл	8,043,998,412.49	-
42220	Гадаад валют	8,043,998,412.49	-
42222	Олон улсын санхүүгийн байгууллагаас	8,043,998,412.49	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	(7,169,197,837.62)	18,615,456,054.26
51	Засгийн газрын хувь оролцоо	(7,169,197,837.62)	18,615,456,054.26
51200	Хуримтлагдсан үр дүн	(7,169,197,837.62)	18,615,456,054.26
51210	Өмнөх үеийн үр дүн	(4,098,693,030.79)	874,800,574.87
51220	Тайлант үеийн үр дүн	(3,070,504,806.83)	17,740,655,479.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	874,800,574.87	18,618,171,054.26

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	30,492,689.50	20,379,413,890.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,492,689.50	20,379,413,890.06
120	Нийтлэг татварын бус орлого	30,492,689.50	20,379,413,890.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,492,689.50	20,379,413,890.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,492,689.50	44,048,427.71
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	20,335,365,462.35
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,055,985,488.51	2,654,717,586.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,909,870,961.87	2,651,717,586.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,909,870,961.87	2,463,487,790.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	421,129,016.21	396,215,810.26
210101	Үндсэн цалин	421,129,016.21	396,215,810.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,174,024.03	49,553,434.58
210201	Тэтгэврийн даатгал	50,174,024.03	49,553,434.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,000,000.00	41,330,181.81
210304	Байрны түрээс	82,000,000.00	41,330,181.81
2104	Хангамж, бараа материалын зардал	19,034,842.08	29,445,763.16
210401	Бичиг хэрэг	4,315,510.35	8,446,545.18
210402	Тээвэр, шатахуун	4,439,400.00	6,310,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,163,352.73	9,163,870.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,116,579.00	5,525,347.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,480,885.55	990,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	565,000.00	990,000.00
210604	Урсгал засвар	3,915,885.55	-
2107	Томилолт, зочны зардал	22,507,168.69	5,277,272.72
210701	Гадаад албан томилолт	10,156,325.88	-
210702	Дотоод албан томилолт	9,869,627.36	2,670,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,481,215.45	2,607,272.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,929,786,222.60	1,876,368,703.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,919,583,134.48	1,857,035,466.95
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,560,000.00	14,290,744.29
210803	Даатгалын үйлчилгээ	4,315,800.00	4,338,996.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,300.00	199,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	750,000.00	100,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	377,988.12	404,195.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	380,758,802.71	64,306,624.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	358,149,527.90	44,048,427.71
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,609,274.81	20,258,196.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	188,229,796.43
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	188,229,796.43
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	188,229,796.43
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	146,114,526.64	3,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	146,114,526.64	3,000,000.00

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
221001	Их засвар	146,114,526.64	3,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(3,025,492,799.01)	17,724,696,303.36
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	58,652,639.64
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	58,652,639.64
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	45,012,007.82	42,693,463.61
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	45,012,007.82	383,963.61
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	-	42,309,500.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(3,070,504,806.83)	17,740,655,479.39

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,386,431,327.87	20,389,041,459.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,386,431,327.87	20,389,041,459.95
120	Нийтлэг татварын бус орлого	2,386,431,327.87	20,389,041,459.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,386,431,327.87	20,389,041,459.95
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,492,689.50	44,048,427.71
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,355,938,638.37	20,335,365,462.35
120009	Бусад орлого	-	9,627,569.89
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,658,391,159.16	2,638,371,959.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,658,391,159.16	2,638,371,959.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,658,391,159.16	2,594,323,531.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,000,000.00	41,330,181.81
210304	Байрны түрээс	82,000,000.00	41,330,181.81
2104	Хангамж, бараа материалын зардал	19,034,842.08	-
210401	Бичиг хэрэг	3,805,510.35	-
210402	Тээвэр, шатахуун	4,439,400.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,163,352.73	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,626,579.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,480,885.55	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	565,000.00	-
210604	Урсгал засвар	3,915,885.55	-
2107	Томилолт, зочны зардал	21,940,568.69	2,670,000.00
210702	Дотоод албан томилолт	19,459,353.24	2,670,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,481,215.45	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,401,655,862.84	2,352,465,983.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,391,452,774.72	2,352,465,983.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,560,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	4,315,800.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	750,000.00	-

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	377,988.12	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,279,000.00	197,857,366.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,000,000.00	197,857,366.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	74,279,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	44,048,427.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	44,048,427.71
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,048,427.71
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(271,959,831.29)	17,750,669,500.26
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	374,985,054.54	14,796,813,578.93
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	374,985,054.54	14,796,813,578.93
2200	Дотоод эх үүсвэрээр	374,985,054.54	14,796,813,578.93
221001	Их засвар	146,114,526.64	237,289,409.00
222001	Тоног төхөөрөмж	228,870,527.90	14,559,524,169.93
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(374,985,054.54)	(14,796,813,578.93)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	59,658,396.90	58,268,676.03
14	Бусад эх үүсвэр	59,658,396.90	58,268,676.03
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	59,658,396.90	58,268,676.03
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(587,286,488.93)	3,012,124,597.36
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,315,459,008.66	728,172,519.73
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	728,172,519.73	3,740,297,117.09

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	(4,098,693,030.79)	(4,098,693,030.79)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(4,098,693,030.79)	(4,098,693,030.79)
9	Тайлант үеийн үр дүн	(3,070,504,806.83)	(3,070,504,806.83)
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	(7,169,197,837.62)	(7,169,197,837.62)
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	(7,169,197,837.62)	(7,169,197,837.62)
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,043,998,412.49	8,043,998,412.49
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	874,800,574.87	874,800,574.87
19	Тайлант үеийн үр дүн	17,740,655,479.39	17,740,655,479.39
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,615,456,054.26	18,615,456,054.26

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	%
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,812,612,700.00	17,428,272,968.73	1,384,339,731.27	93%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,539,612,700.00	2,631,459,389.80	908,153,310.20	74%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,539,612,700.00	2,631,459,389.80	908,153,310.20	74%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,336,000.00	41,330,181.81	31,005,818.19	57%
210304	Байрны түрээс	72,336,000.00	41,330,181.81	31,005,818.19	57%
2107	Томилолт, зочны зардал	48,184,000.00	2,670,000.00	45,514,000.00	6%
210702	Дотоод албан томилолт	48,184,000.00	2,670,000.00	45,514,000.00	6%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,832,984,700.00	2,352,465,983.85	480,518,716.15	83%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,832,984,700.00	2,352,465,983.85	480,518,716.15	83%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	586,108,000.00	234,993,224.14	351,114,775.86	40%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	586,108,000.00	234,993,224.14	351,114,775.86	40%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,273,000,000.00	14,796,813,578.93	476,186,421.07	97%
221001	Их засвар	273,000,000.00	237,289,409.00	35,710,591.00	87%
222001	Тоног төхөөрөмж	15,000,000,000.00	14,559,524,169.93	440,475,830.07	97%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,812,612,700.00	20,379,413,890.06	(1,566,801,190.06)	108%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,812,612,700.00	20,379,413,890.06	(1,566,801,190.06)	108%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	44,048,427.71	(44,048,427.71)	100%
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	18,812,612,700.00	20,335,365,462.35	(1,522,752,762.35)	108%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	728,172,519.73	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,679,313,441.06	-	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	ХЭУЧД төсөл		сая төгрөг	САГ-2020/740/СТА-ТХН

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Биет бус хөрөнгө, биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдуулга дансны эхний үлдэгдэл нь өмнө оны аудитлагдсан үлдэгдлээс 271.2 мянган төгрөгөөр илүү	0.271	Залруулах	Ерөнхий нягтлан бодогч	Д.Уранчимэг
2	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлсөн 14,751,504.1 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3.2 "Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын дансуудад хуримтлуулан бүртгэнэ" заалтыг тус тус зөрчсөн байна.	14,751.6	Залруулах.	Ерөнхий нягтлан бодогч	Д.Уранчимэг
3	ТХН-ийн 16,569,387.1 мянган төгрөгийн тайлант хугацааны худалдан авалтыг НӨАТ-ын хэрэглэгчийн системтэй тулган шалгахад 616,517.5 мянган төгрөгийн НӨАТ-с чөлөөлөгдсөн худалдан авалт, 2,886.4 мянган төгрөгийн НӨАТ-с чөлөөлөгдөөгүй худалдан авалт бүртгэгдсэн боловч 15,952,869.6 мянган төгрөгийн худалдан авалт огт бүртгэгдээгүй, ТХН нь төлбөрийн баримтыг худалдан авагч нараас шаардаж, анхан шатны баримтандаа хавсаргаагүй нь албан татвар суутган төлөгч буюу тус ТХН-ийн харилцагч,	15,952.8	Зөвлөмж өгөх.	Ерөнхий нягтлан бодогч Төслийн туслах	Д.Уранчимэг Б.Мөнхзул

	<p>бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нь санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлсэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтыг ТХН хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p>				
4	<p>Тайлант хугацаанд хувь хүнээс ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний төлбөрт нийт 130,435.6 мянган төгрөг төлсөн боловч түүнд ногдуулах 19,861.6 мянган төгрөгийн НДШ, 11,317.5 мянган төгрөгийн ХХОАТ-ыг тус тус суутгаж, тайлагнаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.2 "Албан татвар төлөгч энэ хуулийн 11.1.6, 12 дугаар зүйл, 13.1.1, 14.1.2, 14.1.3-т заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.1-д заасан хувиар, 8.1.6-д заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.2.2-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулан төлж, албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэн харьяа татварын албаар баталгаажуулах бөгөөд татварын жилийн эцэст уг албатай татварын тооцоо хийнэ.", Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.2 "Нийгмийн даатгалд өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;" заалтыг тус тус зөрчсөн байна.</p>	31.2	<p>Албан шаардлага хүргүүлэх.</p>	<p>Төслийн зохицуулагч</p> <p>Ерөнхий нягтлан бодогч</p>	<p>Б.Бямбадорж</p> <p>Д.Уранчимэг</p>

5	<p>Өмнөх жилийн аудитлагдсан тайланд дараагийн аудитаар авч үзэх чухал асуудлаар дурдсан АХБ-ны зээлийн үлдэгдэл 8,043,998.4 мянган төгрөгийг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.", Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 2.2 "Ажил үйлчилгээ (нийлүүлсэн бүтээгдэхүүн)-ний орлогыг аккрузл суурьт үндэслэн тайлант хугацааны туршид хуримтлуулан бүртгэнэ." заалтуудыг тус тус зөрчсөн байна.</p>	8,044.0	Залруулах.	Ерөнхий нягтлан бодогч	Д.Уранчимэг
6	<p>Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2018.11.02-ны өдөр “Натур тур” ХХК-тай 140 м.кв талбайг 40.0 мянган төгрөгөөр түрээслэхээр №2018/09 тоот гэрээ байгуулж тайлант онд нийт 41,330.2 мянган төгрөг төлсөн байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018 оны №01 дугаартай хуралдааны тэмдэглэлд заасан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн дээд хязгаар 30.0 мянган төгрөгөөс ихгүй байх” заалтыг зөрчсөн байна.</p>	11.9	Зөвлөмж өгөх.	Төслийн зохицуулагч Ерөнхий нягтлан бодогч	Б.Бямбадорж, Д.Уранчимэг
7	<p>Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь нь Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар бүлэг 6 дугаар зүйлд заасан 10 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан байна.</p>		Зөвлөмж өгөх.	Төслийн зохицуулагч, Ерөнхий нягтлан бодогч	Б.Бямбадорж, Д.Уранчимэг
Алдаа зөрчлийн нийт дүн		38,791.8			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 04 дугаар сарын 24 № 02/2020
СЭГ-0000/740/СТА-ТХН
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх МОН-3243 төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Хувь хүнтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу төлсөн нийт 130,435.6 мянган төгрөгийн төлбөрт ногдуулах 19,861.6 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл, 11,317.5 мянган төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг тус тус суутгаж, харьяа татвар болон нийгмийн даатгалын албад тайлагнаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйл 27.2 "Албан татвар төлөгч энэ хуулийн 11.1.6, 12 дугаар зүйл, 13.1.1, 14.1.2, 14.1.3-т заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.1-д заасан хувиар, 8.1.6-д заасан орлого олж байгаа бол уг орлогод энэ хуулийн 23.2.2-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулан төлж, албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэн харьяа татварын албаар баталгаажуулах бөгөөд татварын жилийн эцэст уг албатай татварын тооцоо хийнэ.", Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.2 "Нийгмийн даатгалд өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;" заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх...” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хувь хүнтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар тодорхой тусгаж, хувь хүний орлогын албан татварыг суутган тайлагнаагүй зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх МОН-3243 төсөл”-ийн Зохицуулагч Б.Бямбадорж, Ерөнхий нягтлан бодогч Д.Уранчимэг нарт үүрэг болгосугай.

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР
Ц.ХОСЖАРГАЛ

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
“ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ МОН-3243 ТӨСӨЛ”-ИЙН
ЗОХИЦУУЛАГЧ

Б.БЯМБАДОРЖ
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
Д.УРАНЧИМЭГ - 2

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:
ГРАНТ ТОРНТОН АУДИТ
ХХК-ИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР
Б.ДЭЛГЭРМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага томируулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.